



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

205 /205/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.12.21

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

## БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 110 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН “ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ИТГЭЛЦЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ

1978 он.

БХЯ-ны сайдын “Хугацаат цэргийн алба хаагчдын ахуй амьдралд тавих халамж анхаарлыг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай” тушаал гарчээ.



Батлан хамгаалах яам, ҮБХИС, БХЭШХ хамтран 2013 оноос эхлэн жил бүр Зүүн хойд Азийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж ирсэн уламжлалтай. Энэ жилийн хурлыг БХЯ үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойд зориулан “Зүүн хойд Азийн аюулгүй байдал: Итгэлцлийг бэхжүүлэх нь” сэдвээр ҮБХИС-ийн олон улсын хурлын “Сүбээдэй” танхимд өнөөдөр зохион байгууллаа. Хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалахын сайд асан Ц.Цолмон, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Түвэд судлалын хүрээлэнгийн судлаач Юлия Григорьева, БНХАУ-ын Олон улсын стратегийн хүрээлэнгийн ахлах судлаач Жан Вэй нарын хүндэт зочид төлөөлөгчид оролцов.

ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, улс орнуудын аюулгүй байдлын тулгамдаж буй асуудлуудын талаарх судлаачдын санал, судалгааны ажлын үр дүн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэхэд чиглэсэн юм.

ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд, Будда судлалын хүрээлэн, БНХАУ-ын Олон улсын стратеги судлалын хүрээлэн, Японы Рицүмэйканы их сургууль, дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудаас Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Стратеги судалгааны хүрээлэн, Аюулгүй байдал судлалын хүрээлэн, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Гамшиг судлалын хүрээлэн, ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Монгол Улсын их сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургууль, Монголын Дипломатын Академи, Зүүн хойд Азийн аюулгүй байдал, стратеги судлалын хүрээлэн, Евро азийн стратеги судлалын хүрээлэн зэрэг 10 гаруй байгууллагын судлаачид оролцож Зүүн хойд Азийн аюулгүй байдал, итгэлцлийг бэхжүүлэх асуудлаар илтгэл хэлэлцүүлээ.

Монгол Улс одоогийн байдлаар гадаадын 32 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон хамтын ажиллагаатай байгаагаас 16 улстай идэвхтэй харилцдаг. Мөн манай улсаас 10 орчим улсад цэргийн атташе хавсран суулгадаг бол тус хуралд ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, АНУ, БНТУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэргэдэх цэргийн атташе нар уригдан оролцож, санал бодлоо илэрхийлэв.

Түүнчлэн энэ удаагийн хурлаар Зүүн хойд Азийн аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлтүүд, цаашдын чиг хандлага, бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэхэд цэргийн дипломатын болон эдийн засгийн бодлогын үүрэг, 2022 онд Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын орчин хэрхэн хувьсан өөрчлөгдөх талаар болон бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэхэд Монгол Улсын оролцооны талаар сонирхолтой илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Цаашид Монгол Улс дэлхий нийтийн болон бүс нутгийн тұлгамдсан асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ чанд биелүүлэн, энхийг дэмжих чадавхаа бэхжүүлэхэд хамтран ажиллахад ихээхэн ач холбогдолтой хурал болов.



### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-25

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	24

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,851.0
EUR	3,171.0	3,242.0
CNY	444.30	447.70
RUB	37.60	39.10
JPY	24.77	25.36
KRW	2.36	2.45

### ЗУРХАЙ

2021.12.21 МЯГМАР ГАРАГ  
/БИЛГИЙН ТООЛЛЫН 17/

### ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс доройтно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.39-17.02

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал:

Отгоргүй

Энэ өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, лусыг тахиж, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн.

Сэтгэлд сэтгэл газар очих, газар хагалах, ус булгийн эх малтах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үрээлгэх буюу засуулахад тохиромжгүй. ДОРНЫН ЗУРХАЙ: Хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд ЭЭРЭГ сайн

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН  
2.264.437 /69.6%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН  
2,160,217 /66.4%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН  
850,958 26,1%

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
6787 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
105

ЭДГЭРСЭН  
6554

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 275,793,114

Эдгэрсэн  
Нийт: 247,357,688

Нас барсан  
Нийт: 5,376,591

цахим шууданд

## “ТУСГААР ТОГТНОЛ-2021” ПРАКТИК БУУДЛАГЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН БОЛНО



байгуулагдана. Тэмцээнийг БХЯ, Практик буудлагын холбоо, ЗХЖШ-ын томилгоот алба хаагчид зохион байгуулах юм. Энэхүү тэмцээний зорилго нь алба хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах,

Монгол Улсад Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойд зориулсан Батлан хамгаалахын сайдын нэрэмжит “Тусгаар тогтнол-2021” практик буудлагын улсын аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 23, 24-ний өдрүүдэд Монголын практик буудлагын холбооны төв клубийн буудлагын талбайд зохион



Практик буудлагаар хичээллэгч тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ буудлагын тамирчдын залуу халааг бэлтгэж цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгджээ.

Тэмцээнд одоогоор Төрийн цэргийн байгууллагууд, Монголын практик буудлагын холбоо, Мэргэн буудлагын “Өрлөг төв” ТББ, Монголын хамгаалалтын буудлагын холбоо, Моголын буудлага спортын холбооны тамирчид оролцохоо мэдэгдээд байна.



## ЦЭЦЭЭ ГҮНИЙ ОРГИЛД ...

### Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Тус ангийн бие бүрэлдэхүүн энэ сарын 10 километрийн явган маршаар Цэцээ гүн уулын оргилд гарсан бөгөөд энэ үеэр салбар бүр дөрвөн баг болж олс таталт, цасны сумогоор өрсөлдөв. Мөн эмэгтэй цэргийн алба хаагчдын дунд “Зангиа хэн хурдан зангидах вэ”, эрэгтэй цэргийн алба хаагчдын дунд “Дээлийн товч хэн хурдан зангидах вэ” зэрэг оюун ухаан сорьсон тэмцээнийг зохион байгууллаа.

Олс таталтын тэмцээнд дэд хурандаа Г.Баярхүү ахлагчтай “Соёмбо” баг, цасны сумод



ахлах дэслэгч Б.Доржсүрэн, оюун ухааны тэмцээнд дэслэгч Э.Номин, ахлах ахлагч Г.Гансүх

нар амжилттай оролцон тэргүүлж өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйлээр шагнагдав.



## БАЙНГЫН БҮРЭЛДЭХҮҮН КАРАОКЕ ДУУГААР ӨРСӨЛДӨВ

### Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Байнгын бие бүрэлдэхүүний нөхөрсөг, гар нийлэмжтэй ажиллагааг хангах, урлагийн мэдрэмжийг нь дээшлүүлэх, авьяасыг нь нээн илрүүлж хөгжүүлэх зорилгоор тус тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнд нийт 10 баг оролцож 4 төрлөөр авьяас чадвараа сорьсноос Захиргаа, сургалт, соёл хүмүүжлийн албаны “Ягахан халгайнууд” баг тэргүүн байр, Материал техникийн хангалтын албаны

“Цахирмаа” баг дэд байр, Ажиллагааны удирдлагын тасгийн “АСЕ” баг гутгаар байрт тус тус шалгарлаа.

Тэмцээний шүүгчээр Захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Г.Хатанбаатар, Үлээвэр найрал хөгжмийн Ахлах хөгжимчин МУСТА, ахлах ахлагч Г.Батбаяр, Үлээвэр найрал хөгжмийн, хөгжимчин МУСТА, ахлах ахлагч Е.Дашзэвэг нар ажиллав. Тэмцээний төгсгөлд шүүгч нарын төлөөлөл бие бүрэлдэхүүнд саксафон хөгжмийн аялгуугаар ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

## “НАЛАЙХ” АЭРОДРОМЫГ ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАВ



### Зэвсэгт хүчний 337 дугаар анги

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр, АЦК-ын Улсын нисэхийн хэлтсийн дарга хурандаа Н.Очирбат, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагч хурандаа Г.Бат-Орших нар энэ сарын 20-ны өдөр Монгол

Улс, Оросын Холбооны Улсын Батлан хамгаалах яамд хоорондын цэрэг-техникийн хамтын ажиллагааны холбогдох гэрээний дагуу “Налайх” аэродромыг шинэчлэн сайжруулах, гүйцэтгэн тоноглох ажлын хүрээнд хийгдсэн онгоц асааж шалгах байр, нисгэгч, техникчдийн ажлын байрны

гүйцэтгэлтэй танилцаж, тус байруудыг хүлээн авах ажиллагаанд оролцлоо. Энэ үеэр Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр дээрх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн ОХУ-ын мэргэжилтнүүдэд талархал илэрхийлж гарын бэлэг гардуулав.



## “ИРГЭДИЙН СПОРТЫН НААДАМ”-Д ТЭРГҮҮЛЭВ

### Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Завхан аймгийн “Иргэдийн спортын наадам” энэ сарын 13-17-ны өдрүүдэд өртөөчилсөн марафон, сагсан бөмбөг, гар бөмбөг, олс таталт зэрэг төрлүүдээр болж өндөрлөлөө.

Тус наадамд нийт 12 баг тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн баг тамирчид сагсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй болон олс



таталтын төрөлд тэргүүн байрт, гар бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй, өртөөчилсөн марафон гүйлтийн төрөлд 4 дүгээр байрт тус тус шалгарав.

Тэмцээний хаалтын ажиллагаанд Завхан аймгийн ИТХ-ын дарга Б.Улам-Оргих оролцсон бөгөөд тэрээр орон нутгийн ард иргэд, албан байгууллагууд энэхүү наадамд ихээхэн ач холбогдол өгч оролцсонд баярлаж байгаа илэрхийлэн тэргүүн байруудад шалгарсан баг тамирчдад шагнал гардуулсан юм.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



“Соёмбо” сонин



“Дуулга” студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ. \* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ. \* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)